

ЭРЧИМ ХҮЧНИЙ ЯАМНЫ
ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ
ГАЗРЫН ДАРГА Л.БАТСАЙХАН ТАНАА

Журам батлуулах тухай

Төрийн хяналт шалгалтын тухай хууль, Нийтлэг журам батлах тухай Засгийн Газрын 2011 оны 311 дүгээр тогтоолд заасны дагуу “Улаанбаатар дулааны сүлжээ ХК-ийн үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалт хийх журам”-ыг хавсралтаар хүргүүлж байна. Холбогдох арга хэмжээ авч өгнө үү.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

Р.ХАЙДАВ

Улаанбаатар дулааны сүлжээ ХК-ийн үйл
ажиллагаанд дотоод хяналт шалгалт хийх журам

Нэг. Дотоод хяналт шалгалтын зарчим, зорилго, хамрах хүрээ

1.1. Тус компани нь дотоод хяналт шалгалт зохион байгуулахдаа энэхүү журмаас гадна хууль тогтоомж, эрх бүхий байгууллагаас нийтээр дагаж мөрдүүлэхээр батлан гаргасан эрх зүйн акт, шийдвэрийг дагаж мөрдөнө.

1.2. Дотоод хяналт шалгалт нь хууль дээдлэх, хараат бус, ил тод, шударга, хөндлөнгийн нөлөөллөөс ангид байх зарчим баримтлана.

1.3. Дотоод хяналт шалгалтын зорилго нь компанийн үйл ажиллагаа, зах зээлд нийлүүлж буй бараа, бүтээгдэхүүн, үйлчилгээ нь хууль тогтоомж, Засгийн Газрын тогтоол, шийдвэр, эрх бүхий бусад байгууллага, албан тушаалтны батлан гаргасан шийдвэр, дүрэм, журам, стандарт, норм, компанийн дотоод дүрэм, журмын хэрэгжилтэд хяналт тавьж, илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах, гэм буруутай этгээдэд хариуцлага хүлээлгэхэд оршино.

1.4. Дотоод хяналт шалгалт нь компанийн үйл ажиллагааг бүрэн хамарсан байх бөгөөд зохих удирдамж, төлөвлөгөөний дагуу хийгдэнэ.

Хоёр. Дотоод хяналтын нэгжийн эрх, үүрэг

2.1. Компанийн дотоод хяналтыг Техник хяналт, дотоод аудитын алба эрхлэн гүйцэтгэх бөгөөд байгууллагын удирдлагад шууд захирагдана.

2.2. Ажилтан нь тус компанийн үйл ажиллагааны чиглэлээр боловсрол эзэмшиж, мэргэшсэн, ажлын дадлага туршлагатай байна.

2.3. Техник хяналт, дотоод аудитын алба нь ажлаа жилээр төлөвлөж, мөрдөж ажиллана.

2.4. Компанийн хэмжээнд зохион байгуулсан шалгалтын ажлын дүн, авсан арга хэмжээний талаар улиралд нэгээс доошгүй удаа компанийн удирдлагын хурлаар хэлэлцүүлж, шаардлагатай бол шийдвэр гаргуулж, хамт олонд мэдээлнэ.

2.5. Техник хяналт, дотоод аудитын албаны ажилтан нь дараах эрх, үүрэгтэй байна.

2.5.1. Хяналт шалгалт явуулахдаа салбар, албадын удирдлагатай шууд харьцаж, тэдгээрээс шаардлагатай мэдээ, судалгаа гаргуулах, холбогдох ажилтны ажлыг шалгаж танилцах, илэрсэн зөрчил, дутагдлын талаар тайлбар гаруулах, шалтгаан нөхцлийг тодруулж, зөрчлийг арилгуулах, дахин гаргуулахгүй байх талаар арга хэмжээ авах;

2.5.2. Шаардлагатай бол илэрсэн зөрчил, дутагдлын шалтгаан нөхцлийг арилгах тухай болон зөрчил гаргасан ажилтанд хариуцлага тооцож, сахилгын шийтгэл ногдуулах талаар компанийн удирдлагад санал тавьж шийдвэрлүүлэх;

2.5.3. Хяналт шалгалтын явцад илэрсэн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх, урьдчилан сэргийлэх талаар мэргэжил арга зүйн зааварчилга, зөвлөгөө өгөх;

2.5.4. Дотоод хяналт шалгалтын үр нөлөө болон мэргэжлийн чадавхийг дээшлүүлэх зорилгоор хөндлөнгийн хяналтын байгууллагаас мэргэжил арга зүйн зөвлөгөө авах, шаардлагатай бол асуудлыг хууль хяналтын байгууллагаар шийдвэрлүүлэх, хамтран ажиллах талаар санал боловсруулж, удирдлагад танилцуулах;

2.5.5. Байгууллагын үйл ажиллагаанд учирч болзошгүй эрсдэл, холбогдох хууль тогтоомж, дүрэм журам, стандартын хэрэгжилт болон зөрчлийн талаарх мэдээллээр удирдлагыг хангах;

2.5.6. Захиргаа, удирдлагын албатай хамтран ажиллагсдын ажлын байрны нөхцөл, эрүүл ахуйн шаардлага хангаж байгаа эсэхэд мөн түүнчлэн, хөдөлмөрийн дотоод журам болон холбогдох дүрэм, журмын биелэлтэд хяналт тавьж ажиллана.

Гурав. Дотоод хяналт шалгалтын үйл ажиллагааны чиглэл

3.1. Дотоод хяналт шалгалтыг дараах чиглэлээр зохион байгуулна.

3.1.1. Хууль тогтоомж, Ерөнхийлөгчийн зарлиг, Засгийн газрын шийдвэр, нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ тогтоосон эрх зүйн актын хэрэгжилт болон тус байгууллагын гүйцэтгэх үүргийн биелэлтэд хяналт тавих чиглэлээр:

- Эрх бүхий байгууллагаас эрчим хүчний салбарт дагаж мөрдүүлэхээр тогтоосон хууль, тогтоомж, дүрэм, журмын хэрэгжилтэд хяналт тавьж, гарсан зөрчлийг арилгах;

- Байгууллагын дотоод сахилга бат, дэг журам, цаг ашиглалтыг сайжруулах, Хөдөлмөрийн тухай хууль, түүнтэй холбоотой тогтоол, тушаал, шийдвэр, хамтын хэлэлцээр, хамтын гэрээ, дотоодод мөрдөгдөж буй дүрэм, журам, тушаал, шийдвэрийн биелэлт, аж ахуйн болон бусад гэрээ, хэлэлцээр байгуулж, хэрэгжүүлэх явц, хөдөлмөрийн хамтын маргааны зохицуулалтад хяналт тавьж ажиллана.

3.1.2. Техник ашиглалт, их засвар шинэчлэлтийн ажилд хийх хяналт шалгалт:

- Дулааны төв шугам тоноглолын ашиглалтын байдалд үзлэг шалгалт хийж илэрсэн зөрчлийг арилгах талаар холбогдох албанд албан даалгавар өгч гүйцэтгэлийг газар дээр нь шалгах;

- Улсын төсвийн хөрөнгөөр болон хотын хөрөнгө оруулалтаар хийгдэж байгаа ажлуудад үзлэг шалгалт хийж, илэрсэн зөрчлийг арилгуулах талаар гүйцэтгэгч компани, холбогдох байгууллагуудад албан шаардлага тавьж, зөрчлийг арилгуулах;

- Зуны их засварын үеэр дулааны шугам тоноглолын засварын ажилд хяналт тавихын зэрэгцээ их засвараар хийсэн ажлыг хүлээж авах комисс гарган ажиллуулж, засвар, шинэчлэлт хийсэн шугам тоноглолыг ашиглалтад хүлээж авах;

- Дулааны шугам тоноглолд гарсан гэмтэл саатлыг судлан бүртгэж, шаардлагатай тохиолдолд техникийн дүгнэлт гаргах комиссын хурлаар хэлэлцүүлж шийдвэрлүүлэх;

- Дулааны шугамын дулаалга, тулгуур, компенсатор, худаг камер, узель павилонуудын ашиглалтын байдалд үзлэг шалгалт хийж, илэрсэн зөрчлийг арилгуулах;

- Цахилгаан тоноглолтой хаалт, насос станцуудын тоноглолуудын бэлэн байдлыг хангуулах талаар үзлэг шалгалт хийж, илэрсэн зөрчлийг арилгуулах;

- Дулааны шугамын хамгаалалтын зурваст үзлэг шалгалт хийж, илэрсэн зөрчлийг арилгуулах, холбогдох байгууллагуудтай хамтран ажиллах;

- Хэрэглэгчдийн шугам тоноглолд үзлэг шалгалт хийж, дулаан хангамжийн хэвийн найдвартай ажиллагааг хангах талаар холбогдох арга хэмжээ авч ажиллана.

3.1.3. Үйлдвэрлэж байгаа болон борлуулж байгаа бараа, бүтээгдэхүүн, ажил үйлчилгээний чанар, технологи ажиллагаа, техник ашиглалтын дүрмийг хэрэгжилтэд тавих хяналт шалгалт:

- ДҮТ-өөс батласан өвөл, зуны горим ажиллагааны хүрээнд сүлжээний даралтын горимыг бариулах, гадна агаарын температураас хамааран сүлжээний шууд усны температурын горимыг мөрдүүлж биелэлтэд хяналт тавьж ажиллах ба сүлжээний параметрийг дор дурдсан хэмжээнээс илүүгүй хэлбэлзэлтэй барьж ажиллана. Үүнд:

а/ Сүлжээний шууд усны температурыг ± 4 хэмээс ихгүй.

б/ Сүлжээний шууд усны даралтыг ± 5 -аас ихгүй.

- Сүлжээний нэмэлт усанд агуулагдах химийн нэгдлүүдийн хэмжээг ТАД-ийн шаардлагад нийцэж байгаа эсэхийг шалгаж, гарсан зөрчлийг арилгуулах техник зохион байгуулалтын арга хэмжээг авах;

- Батлагдсан горим ажиллагааны хүрээнд хэрэглэгчдэд түгээж буй дулааны эрчим хүчний чанарт хяналт тавьж, сүлжээний даралт температурын горимыг тооцооны дагуу барьж байгаа эсэхийг шалган сүлжээний хэвийн үйл ажиллагааг хангуулж ажиллах;

- Компанийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй дулааны шугам тоноглолын ашиглалтын байдалд үзлэг шалгалт хийх, үнэлгээ дүгнэлт өгөх, болзошгүй аваар саатлаас урьдчилан сэргийлэх талаар заавар зөвлөмжөөр хангах, илэрсэн зөрчлийг арилгах үүрэг даалгаврыг хариуцсан алба, ажилтанд өгч, биелэлтэд хяналт тавих;

- Улсын болон орон нутгийн хөрөнгө оруулалтаар хийгдэж байгаа засвар шинэчлэлтийн ажлуудын гүйцэтгэлд үзлэг шалгалт хийх, технологийн болон хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны талаар илэрсэн зөрчил дутагдлыг арилгах арга хэмжээг авахуулах, томилогдсон хяналтын инженерүүдэд үүрэг даалгавар өгөх;

- Их засвар шинэчлэлтийн ажлын хүрээнд хийгдэж байгаа засварын ажлын явцыг батлагдсан хувиарийн дагуу тогтмол шалгах;

- Дулааны төв ба салаа шугам, даралт өргөх станцын үндсэн ба туслах тоноглолд гарсан гэмтэл саатлыг судлан бүртгэх, техникийн комиссын дүгнэлт гаргах, комиссын хурлаар оруулж шийдвэр гаргуулах, засвар шинэчлэлтийн ажлын төлөвлөгөөнд тусгах санал оруулах;

- Хэрэглэгчдийн дулааны шугам, узель, халаалтын ба хэрэгцээний халуун усны бойлер, дулааны тоолуур бусад тоног төхөөрөмжийн ажиллагаа, ашиглалтын байдалд үзлэг шалгалт хийх, хариуцсан салбар, албадын ажилд үнэлэлт дүгнэлт өгөх, технологи ажиллагааны зөрчил доголдлыг илрүүлэх, ажлын хариуцлагыг дээшлүүлэх талаар заавар зөвлөмж, албан шаардлага өгөх биелэлтийг шалгах;

- Шугам сүлжээний аюулгүй байдлыг хангах, хамгаалалтын зурвастай холбоотой зөрчлийг эрт илрүүлэх талаар хариуцсан алба салбаруудын үүрэг хариуцлагыг дээшлүүлэхэд чиглэсэн зохион байгуулалтын арга хэмжээг авч хэрэгжүүлэх, түүний мөрөөр илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах, нийслэл, дүүрэг, бусад холбогдох байгууллагуудтай хамтран ажиллах;

- Дулааны шугам сүлжээний дамжуулах, түгээх төхөөрөмжийн найдвартай ажиллагааг хангаж ажиллах, ажиллагсдыг болзошгүй аваар саатлын үеийн шуурхай ажиллагаанд мэргэшүүлэх, технологийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаар салбар, албадын удирдлагаас өгч байгаа зааварчилгаанд хяналт тавих, ажиллагсдын дунд дасгал сургуулалтыг зохион байгуулах, санал дүгнэлт гаргаж, сургалтын хөтөлбөрт тусгуулж ажиллана.

3.1.4. Хөдөлмөрийн аюулгүй ажиллагааг хангах, ажлын байрны нөхцлийг сайжруулах, стандарт, нормативын биелэлтэд тавих хяналт, шалгалт:

- Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль тогтоомж болон цахилгаан станц, дулааны шугам сүлжээний дулаан-механикийн тоноглолын ашиглалтын үеийн аюулгүй ажиллагааны дүрмийн биелэлтэд хяналт тавьж, гурван шатны үзлэг хийж, заавар, зөвлөмж өгч, илэрсэн зөрчлийг арилгуулах арга хэмжээ авах;

- Төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус засвар үйлчилгээ хийх, гэмтэл саатлыг арилгах үед ажилтнуудын ажлын байрны нөхцөл, аюулгүй ажиллагааны дүрмийн хэрэгжилт, наряд, шийдвэрийн биелэлтийг газар дээр нь шалгаж, хүний эрүүл мэндэд сөрөг, аюултай нөхцөл байдал бий болсон тохиолдолд уг засварын ажлыг яаралтай зогсоож, аюултай нөхцөл байдлыг шуурхай арилгуулах;

- Аюулгүй ажиллагааны мэдлэг олгох сургалт явуулах, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн талаарх мэдлэгийг жил бүр шалгах, аюулгүй ажиллагааны ээлжит бус зааварчилга өгөх, сургалтад хамрагдаагүй, зааварчилга аваагүй, шалгалт өгөөгүй ажилтнаар ажил үүрэг гүйцэтгүүлэхгүй байхыг ажил олгогч нараас шаардах;

- Албадын дарга /ажил олгогч/, хариуцлагатай удирдагч нарын наряд, шийдвэр, зааварчилга өгөлтийн биелэлтэд хяналт тавьж, зөвлөмж хүргүүлэх;

- Хөдөлмөрийн аюултай, хортой нөхцөлд ажил үүрэг гүйцэтгэдэг ажилтнуудад хор саармагжуулах сүү, сүүн бүтээгдэхүүн олгуулах ба түүний хадгалалт, нийлүүлэлт, чанарт хяналт тавих;

- Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн нөхцлийг хангах, арга хэмжээнд шаардагдах хөрөнгийг жил бүрийн төсөв, төлөвлөгөөнд тусган батлуулж, зарцуулалтад хяналт тавих;

- Аюулгүй ажиллагаа, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн талаарх дүрэм, журмыг зөрчсөн ажилтанд компанийн дотоод журамд заасны дагуу хариуцлага тооцох;

- Ажлын байранд галын аюулгүй байдлыг хангуулах, гамшгийн үед мэргэжлийн ангийн бүрэлдэхүүнийг бүрдүүлэх, болзошгүй онц байдлын үед ажиллах төлөвлөгөөг боловсруулж, холбогдох байгууллагуудтай хамтран ажиллах;

- Ажиллагсдын эрүүл мэндийг хамгаалах, эмнэлгийн анхан шатны тусламж, үйлчилгээ үзүүлэх, өвчлөлийг бууруулах, хөдөлмөрийн эрүүл ахуйн шаардлага хангасан ажлын байрны нөхцлийг бүрдүүлэхэд хяналт тавих;

- Хөдөлмөрлөх явцад хүний ажиллах чадвар, эрүүл мэндэд дагнасан буюу хамссан байдлаар нөлөөлөх ажлын байрны болон үйлдвэрлэлийн орчны нөлөөлөлд хяналт тавих;

- Ариун цэвэр, эрүүл ахуйг сайжруулах, эмчлэх, сувилах, нөхөн сэргээх, эрсдлээс хамгаалах үйл ажиллагаанд хяналт тавих;

- Хөдөлмөрлөх явцад хими, физик, биологийн хүчин зүйлсээс шалтгаалан хүний бие махбодь, мэдрэл, сэтгэхүйд өөрчлөлт орж өвчлөх, хөдөлмөрийн чадвараа түр болон бүрэн алдахаас урьдчилан сэргийлэхэд чиглэсэн үйл ажиллагаанд хяналт тавих;

- Компанийн ажиллагсад ажиллах өрөө тасалгаа, эд хогшил, хөдөлмөрлөх нөхцлөөр хэрхэн хангагдаж байгаа болон хөдөлмөрийн сахилга бат, ажлын цаг ашиглалтад хяналт тавьж ажиллана.

3.1.5. Компанийн өмч хөрөнгийн бүртгэл тооцоо, ашиглалт, хадгалалт, хамгаалалт, санхүү бүртгэлийн үйл ажиллагаанд тавих хяналт шалгалт:

- Компанийн санхүүгийн тайлан тэнцлийг ОУНББ-ийн стандартад нийцүүлэн СЯ-наас батлан гаргасан маягт, аргачлалын дагуу үнэн зөв гаргаж байгаа эсэхэд хяналт тавьж зөвлөмж өгөх;

- Нягтлан бодох бүртгэлийн үйл явц, бүртгэл хөтлөлт, анхан шатны баримтын бүрдэлтэд шалгалт хийн дүгнэлт гаргаж, зөвлөмж өгөх;

- Дулааны эрчим хүчээр хангагдаж байгаа гэрээтэй хэрэглэгчдийн дулааны эрчим хүчний төлбөр тооцоог хууль, дүрэм журмын дагуу үнэн зөв бодитойгоор тооцож байгаа эсэхэд хяналт шалгалт хийж, дүгнэлт гарган зөвлөмж өгч, нөхөн төлбөр тавих;

- Компанийн алба нэгжийн зардлын төлөвлөлт, гүйцэтгэлд хяналт тавьж, дүгнэлт гаргах;

- Батлагдсан орон тоо, цалин хөлстэй холбоотой гарсан тушаал шийдвэрийн хэрэгжилтэд хяналт тавьж, дүгнэлт гаргах;

- Мөнгөн хөрөнгө, бараа материал, өр, авлагын үлдэгдлийн баталгаажуулалтыг шалгах;

- Албан тушаалын болон технологийн зориулалттай машины норм, норматив, телефон утасны норм, албан томилолтын зардлын батлагдсан төсөвт багтсан эсэхэд хяналт тавьж, дүгнэлт гаргах;

- Дулаан хангамжийн гэрээтэй хэрэглэгчдэд суурилагдсан дулааны тоолуур, хянах хэмжих хэрэгслийн ашиглалт, хэвийн найдвартай ажиллагаанд хяналт тавьж, тоолуурын тооцоолол, тэдгээрийн үнэн зөв байдлыг хянах;

- Дулаан хангамжийн гэрээтэй хэрэглэгчийн эх үүсвэрийг хянаж шалган, хэмжилт хийж, илэрсэн зөрчлийг удирдлагад танилцуулан шийдвэрлүүлж ажиллана.

Дөрөв. Хариуцлага

4.1. Дотоод хяналт шалгалтын мөрөөр буруутай ажилтанд холбогдох хууль тогтоомж, дотоод журамд заасан хариуцлага ногдуулна.

4.2. Байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалт хийх ажилтнууд нь дотоод хяналт шалгалтын үр нөлөө болон мэргэжлийн чадавхийг дээшлүүлэх зорилгоор хөндлөнгийн хяналтын байгууллагаас мэргэжил арга зүйн зөвлөгөө авах, хамтран ажиллах талаар санал боловсруулан удирдлагад танилцуулж болно.

4.3. Энэхүү журамд заасан эрх, үүргээ хэрэгжүүлэх явцад дотоод хяналт шалгалтын нэгж, ажилтанд аливаа дарамт, шахалт үзүүлэх, үйл ажиллагаанд нь хөндлөнгөөс нөлөөлөхийг хориглоно.

4.4. Дотоод хяналт шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдал нь гэмт хэргийн шинжтэй бол хуулийн байгууллагад хандаж шийдвэрлүүлнэ.

